


Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны “Beacon” хэвлэгдсэний 20 жилийн ойн мэнд хүргэе. **2021 оны 11 сар**



2001 оны 11 сар



2021 оны 11 сар

2011 оны 11 сар



Зураг 1: Аюулгүй ажиллагааны “Beacon” хэвлэгдсэн 20 жил

20 жилийн өмнө CCPS (Химийн Бодисын Үйлдвэрлэлийн Аюулгүй Ажиллагааны Төв)-ийн харьяа компанийн бүлэг төлөөлөгчид уулзаж, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаанд зориулсан шинэ хэвлэмэл боловсруулахаар шийджээ. Ийнхүү талбайн ажилчдад – ялангуяа ашиглалт ба засварын ажилчдад зориулагдсан, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны “Beacon” үүссэн аж. 2001 оны 11 сарын анхны дугаараас эхлэн сар бүр хэвлэгддэг болсон ба одоогоор 30.000 гаруй захиалагч и-мэйлээр хүлээн авч байна. Уншигчдын тоо цөөн хэдэн зуугаас 1 сая орчим болтлоо өсөн нэмэгджээ.

“Beacon”-ы зорилго нь үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны хэрэгцээтэй мэдээллээр талбайн ажилчдыг хангах бөгөөд ханын самбарт байрлуулах, ажилчдын хурал, аюулгүй ажиллагааны хэлэлцүүлэг дээр танилцуулах замаар түгээгддэг.

20 жилийн хугацаанд 200 гаруй ширхэг “Beacon” хэвлэгдсэн ба эдгээрийг доорх архивын линкээр нэвтрэн унших боломжтой.

<https://www.aiche.org/ccps/resources/process-safety-beacon/archives>

Та мэдэх үү?

- Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны “Beacon” бол CCPS-ийн хамгийн олон уншигчтай хэвлэмэл бөгөөд дэлхий даяар 1 сая орчим уншигчтай.
- “Beacon”-нд хэвлэх материалыг тусгай хянах хороо сар бүр шалгаж, үнэн зөв бөгөөд уншигчдад хэрэгцээтэй эсэхийг нь нягталдаг. Өнгөрсөн 20 жилийн хөдөлмөр, хичээл зүтгэлийнх нь төлөө тус хороонд TOM баяр хүргэх ёстой.
- “Beacon” нь одоогоор нийт 40 орны хэл дээр хэвлэгддэг ба чанартай орчуулахын төлөө цаг заваа зориулдаг орчуулагч нарт мөн талархаж байна.
- “Beacon” нь хүн бүрд үнэгүй бөгөөд тогтмол уншихыг хүсвэл доорх линкээр бүртгүүлж болно:
https://aiche.informz.net/AICHE/pages/Beacon_Subscribe_Page
- “Beacon”-ыг хуулбарлах болон бусдад түгээхийг хориглодоггүй, харин ч бүрэн дэмждэг.
- “Beacon”-нд дурдсан ослуудын талаарх мэдээлэл нь тэдгээрт нөлөөлсөн маш олон хүчин зүйлийн зөвхөн цөөн хэсэг нь л байх тохиолдол их байдаг.

Та юу хийж болох вэ?

- “Beacon”-ы талаар багийн гишүүдтэйгээ ярилцаж, өөрсдийн үйл ажиллагаанд нэвтрүүлж болох чухал санааг нь эрэлхийл.
- “Beacon”-ыг уншиж, доорхтой төстэй асуултыг тавь:
 - Ийм үйл явдал манайд тохиолдож болох уу?
 - Ийм ослоос сэргийлэх аюулгүй ажиллагааны ямар хяналтын систем манайд байгаа вэ?
 - Манай хяналтын хэрэгслүүдийн нөхцөл байдал хэвийн байгаа юу?
- “Beacon”-ыг тогтмол уншиж, бусадтай хуваалц.
- “Beacon”-нд зориулсан сэдвийн санаа танд байгаа бол ccps_beacon@aiche.org хаягаар илгээж болно.

Beacon – үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны сургамжуудыг хуваалцсан 20 жил!